



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 34

Мандалговь

Үл хөдлөх хөрөнгөд үнэлгээ тогтоож худалдах,  
акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.4, 6.4.6 дах заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 234,052,58 (хоёр зуун гучин дөрвөн мянга тавин хоёр төгрөг тавин найман мөнгө) төгрөгийн балансын үнэтэй, 196,343,88 (нэг зуун ерэн зургаан мянга гурван зуун дөчин гурван төгрөг наян найман мөнгө) төгрөгийн үлдэгдэл өртөгтэй Орон сууцыг нэгдүгээр хавсралтын дагуу акталж, данснаас хасах, 936,210,32 (есөн зуун гучин зургаан мянга хоёр зуун арван төгрөг гучин хоёр мөнгө) төгрөгийн балансын үнэтэй, 785,375,52 (долоон зуун наян таван мянга гурван зуун далан таван төгрөг тавин хоёр мөнгө) төгрөгийн үлдэгдэл өртөгтэй Орон сууцыг хоёрдугаар хавсралтад заасны дагуу нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Мөнх-Оргил), Орон нутгийн өмчийн газрын дарга (С.Хулан) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд 100 хувь төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;


2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ




Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн  
Х.А. Тогтоолын нэгдүгээр хавсралт

Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын дуудлагын  
худалдаагаар худалдах хөрөнгийн мэдээлэл

№	Барилга байгууламжийн нэр	Зориулалт	Хүчин чадал		Ашигдалтын огноо	Ашигласны хугацаа / жилээр	Тоо хэмжээ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Худалдах доод үнэ	
			хэмжих нэгж	биет хэмжээ								
1	Орон сууц-1	Орон сууц	м.кв	45,4	1989	20	1	234052.58	37708.7	196343.88	1,155,000	
2	Орон сууц-2	Орон сууц	м.кв	45,4	1989	20	1	234052.58	37708.7	196343.88	855,000	
3	Орон сууц-4	Орон сууц	м.кв	45,4	1989	20	1	234052.58	37708.7	196343.88	1,816,000	
4	Орон сууц-5	Орон сууц	м.кв	45,4	1989	20	1	234052.58	37708.7	196343.88	855,000	
								<b>936,210,32</b>	<b>150,834,80</b>	<b>785,375,52</b>	<b>4,681,000</b>	
								(есөн гучин мянга зуун зургаан хоёр арван гучин төгрөг хоёр мөнгө)	(нэг тавин найман гучин мөнгө)	(долоон мянга гурван зуун таван төгрөг тавин мөнгө)	зуун таван гурван далан төгрөг хоёр мөнгө)	

Нийт дүн



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн  
37. тогтоолын хоёрдугаар хавсралт

Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын  
актлах хөрөнгийн мэдээлэл

№	Барилга байгуула мжийн нэр	Зориул алт	Хүчин чадал		Ашигл алтан д орсон огноо	Ашиглал тын нийт хугацаа / жилээр /	Тоо хэмжэ э	Нэгж үнэ	Балансын үнэ	Хуримтлагдса н элэгдэл	Үлдэгдэл өртөг
			хэмжи х нэгж	биет хэмжэ э							
1	Орон сууц-3	Орон сууц	м.кв	45,4	1989	20	1	234,052,58	234,052,58	37,708,70	196,343,88
<b>Нийт дүн</b>											
											196,343,88
											(нэг ерэн мянга зуун гурван дөчин төгрөг наян мөнгө)
											зуун зургаан гурван дөчин төгрөг найман мөнгө)
											зуун зургаан гурван дөчин төгрөг найман мөнгө)